



**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ**

2020 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

Аяны удирдамж, төлөвлөгөө батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйл, 48 дугаар зүйлийн 48.3.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/408 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ЦССҮТ-д хэрэгжүүлэх “Эерэг хандлага-Чанартай тусламж, үйлчилгээний эхлэл” аяны удирдамжийг нэгдүгээр, үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар, алба, тасгийн ажлын үр дүнг үнэлэх Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү аяныг ЭМС-ын 2020 оны А/408 дугаар тушаал, энэ тушаалтай уялдуулан хэрэгжүүлж, хариуцсан ажилтнуудаа 7 хоног тутам үнэлж, сараар нэгтгэн дүнг Ажлын хэсэгт ирүүлж байхыг алба, тасгийн дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Үр дүнгийн болон хандлагын урамшуулалд шаардагдах хөрөнгийг Цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас олгохыг Санхүү бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Б.Өнөрзул/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн ажилтан, хуулийн зөвлөх /Я.Тогтохням/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

D:\bichig hereg\ALBAN BICHIG\Tushaal\tushaal-2020A.docx

080237

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын  
2020 оны 09 сарын 10-ний өдрийн  
А/36 дугаар тушаалын хавсралт

1118266548 9128905

**“ЭЕРЭГ ХАНДЛАГА-ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭХЛЭЛ ”  
АЯНЫ УДИРДАМЖ**

**Нэг. Зорилго**

Байгууллагын соёлыг хөгжүүлэн, ажиллагсадын ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулахад оршино.

**Хоёр. Зорилт**

1. Байгууллагын соёл, үйлчилгээнд мөрдөх журмыг хэвшүүлэх;
2. Эрүүл мэндийн ажилтны ёс зүй, харилцаа, хандлагыг сайжруулах;
3. Тусламж үйлчилгээний мэдээллийн ил тод байдлыг сайжруулах;
4. “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын Дэлхийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх;

**Гурав. Хугацаа**

2020 оны 09 сарын 04 –ний өдрөөс 2020 оны 11 сарын 25-ныг хүртэл

**Дөрөв. Хамрах хүрээ**

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн алба, тасгууд

**Тав.Хариуцах эзэн**

- Цусны чанар, аюулгүй байдлын алба
- Сувилахуй,үйлчилгээний алба
- Ёсзүйн салбар хороо
- Сэтгэлд нийцсэн үйлчилгээний баг

**Зургаа. Хамтран ажиллах**

- Захиргаа, маркетингийн алба
- Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба
- Халдварын сэргийлэлт хяналтын баг

**Долоо. Хүрэх үр дүн**

1. Байгууллагын соёл, үйлчилгээнд мөрдөх журмын хэрэгжилт бүрэн хангагдаж, ажиллагсад, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ.
2. Төвийн ажиллагсад хоорондын харилцаа хандлага сайжирч, алба, тасаг нэгжүүдийн уялдаа холбоо, хамтын ажиллагааны бүтээмж сайжирна.
3. Тусламж үйлчилгээний мэдээллийн ил тод, байдал сайжирч, донор, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ.
4. Үйлчлүүлэгч, ажиллагсадын аюулгүй байдал хангагдана.

#### **Найм. Ажилтны хандлагыг үнэлэх**

1. Ажиллагсадын харилцаа хандлагыг ЭМС-ын 2020 оны А/408 дугаар тушаалын 7 дахь заалтын дагуу 7 хоног, сараар үнэлнэ.
2. Үнэлгээг үндэслэн 100%-ийн үнэлгээ авсан эрүүл мэндийн ажилтанд "Хандлагын 10 хувь"-ийн нэмэгдлийг сарын албан тушаалын үндсэн цалингаас тооцож олгоно.

#### **Ес. Алба, Тасгуудын хандлагын ажлыг үнэлэх**

1. Алба, тасгуудын хамт олны харилцаа хандлагыг сайжруулах чиглэлээр хийж буй ажлыг ЭМС-ын 2020 оны А/408 дугаар тушаалын 8 дахь заалтын дагуу сараар үнэлнэ.
2. Үнэлгээг үндэслэн байр эзлүүлэх бөгөөд эхний 3 байр эзэлсэн алба, тасгийн хамт олныг албан тушаалын сарын үндсэн цалингийн 20%, 15%, 10%-иар тооцон үр дүнгийн урамшуулал олгох бөгөөд сүүлийн 3 байр эзэлсэн алба, тасгийн нийт ажилтны улирлын үр дүнгийн урамшууллыг олгохгүй.



ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын  
2020 оны 09 сарын 10-ний өдрийн  
...А/35... дугаар тушаалын хавсралт

1118266548 ᠎.9128905

“ЭЕРЭГ ХАНДЛАГА-ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭХЛЭЛ”  
АЯНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцах эзэн	Хэрэгжүүлэх алба, тасаг	Хугацаа (сар)		Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Шаар дагда х нөөц
				IX	XI			
орилт 1. Байгууллагын соёл, үйлчилгээнд мөрдөх журмыг хэвшүүлэх								
1.	ЭМС-ын 2020 оны А/408 дугаар тушаал, Байгууллагын соёл, үйлчилгээнд мөрдөх журмыг нийт ажиллагсдад танилцуулах	Сэтгэлд нийцсэн үйлчилгээний баг	Бүх алба, тасаг	+		Ажиллагсадын мэдлэг, хандлага сайжирна.	Тушаал, журмыг нийт ажиллагсдад танилцуулж, баримтжуулсан байна.	-
2.	Дээрх тушаал, журмын хэрэгжилтийг ажлын байр бүрт хэвшүүлэх	Цусны чанар, аюулгүй байдлын алба, Сувилахуй, үйлчилгээний алба, Сэтгэлд нийцсэн үйлчилгээний баг, Ёс зүйн салбар хороо	Бүх алба, тасаг	+	+	Байгууллагын соёл, үйлчилгээнд мөрдөх журмын хэрэгжилт бүрэн хангагдаж, ажиллагсад, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ.	Алба тасаг бүрт үзүүлэх сургалт, зохион байгуулж, ажиллагсад үйлчлүүлэгчтэй инээмсэглэн мөндлөх, үдэх соёлыг хэвшүүлсэн байна.	-

3.	Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэхдээ баримтлах эрх, үүргийг сурталчлах	Ёс зүйн салбар хороо, Сэтгэлд нийцсэн үйлчилгээний баг,	-	+	+	+	Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэхдээ баримтлах эрх, үүргийг үйлчлүүлэгчдэд ил тод байдлаар байрлуулсан байна.	-
----	--	---	---	---	---	---	---	---

**орилт 2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах чиглэлээр**

4.	Ёс зүй, харилцаа хандлагын чиглэлээр сургалт зохион байгуулах	Ёс зүйн салбар хороо	Бүх алба, тасаг	+			Ажиллагсадын мэдлэг, хандлага сайжирна	Мэргэжлийн багшаар сургалт зохион байгуулж, баримтжуулсан байна.	Санху үгийн нөөц
5.	Алба тасаг бүр энэхүү аяны хүрээнд уриа, зорилгоо тодрхойлох	Бүх алба, тасаг	Бүх алба, тасаг	+			Аяны хүрээнд зорилго, зорилт тодорхой болно.	Уриа зорилгоо харагдахуйц газар байршуулсан байх ба ажилтан бүр мэддэг байна.	-
6.	Ажиллагсадын харилцаа хандлага, ажлын хариуцлагыг сайжруулах бүлгийн уулзалт, ярилцлага зохион байгуулах	Сувилахуй, үйлчилгээний алба, Сэтгэлд нийцсэн үйлчилгээний баг, Ёс зүйн салбар хороо	Бүх алба, тасаг	+	+	+	Ажиллагсад хоорондын харилцаа хандлага сайжирч, алба, тасаг нэгжүүдийн уялдаа холбоо, хамтын ажиллагааны бүтээмж сайжирна	Бүлгийн уулзалт, ярилцлагыг 7 хоног бүр зохион байгуулсан байна.	-
7.	Ажлын байран дахь дүрэмт хувцасны журмын хэрэгжилтийг сайжруулах	Сувилахуй, үйлчилгээний алба	Бүх алба, тасаг	+	+	+	Ажиллагсад дүрэмт хувцсаа бүрэн зөв өмсөж, энгэрийн тэмдэг зүүж хэвшсэн эмсөн, үсээ шууж боох, энгэрийн тэмдэг зүүх дадлыг бүрэн хэвшүүлсэн байна.	Ажиллагсад дүрэм хувцсаа бүрэн зөв өмсөж, энгэрийн тэмдэг зүүж хэвшсэн Тусгай мэргэжилтэн, үйлчилгээний ажиллагсад үсний хавчаарыг тогтмол зүүж хэвшсэн байна.	-



8.	Ажлын менежментийг сайжруулах цагийн	Цусны чанар, аюулгүй байдлын алба, Сувилахуй, үйлчилгээний алба, Сэтгэлд нийцсэн үйлчилгээний баг, Захиргаа, маркетингийн алба	Бүх алба, тасаг	+	+	+	Ажиллагсадын ажлын бүтээмж нэмэгдэнэ	6 удаа ажиллагсадын өглөө, оройны ажлын цагийн менежментэд хяналт тавьж, үр дүнг тодорхойлсон байна.	-
9.	Ажлын байранд эмх цэгцтэй байх дадлыг хэвшүүлэх	Цусны чанар, аюулгүй байдлын алба, Сувилахуй, үйлчилгээний алба, Сэтгэлд нийцсэн үйлчилгээний баг	Бүх алба, тасаг	+	+	+	Ажиллагсадын ажлын бүтээмж нэмэгдэнэ.	Ажлын байранд 5С хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.	-
орилт 3. Тусламж үйлчилгээний мэдээллийн ил тод байдлыг сайжруулах чиглэлээр									
10.	Лавлагаа шинжилгээний нэр, төрөл, шинжилгээний ач холбогдлыг танилцуулах хөтөч сувилагчийн чадавхийг сайжруулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх	Сувилахуй, үйлчилгээний алба,	ДЗБТ, ТТ, НЛТ	+	+	+	Лавлагаа шинжилгээ хийлгэж байгаа үйлчлүүлэгчид шинжилгээний ач холбогдолын талаар танилцуулах үр чадвар нэмэгдэнэ.	Хөтөч сувилагч нарт сургалт зохион байгуулсан байна.	-
11.	Төлбөртэй үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчдэд зориулж шинжилгээ хийж байгаа лаборант болон хариуцаж буй эмчийн мэдээллийг ил байрлуулах, үйлчлүүлэгчийн хүсэлтээр шинжилгээний хариуг тайлбарлан зөвлөгөө, мэдээлэл өгч хэвших	Сэтгэлд нийцсэн үйлчилгээний баг	НЛТ	+	+	+	Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж сайжирна.	Мэдээллийн жижиг самбар гаргасан байна. Утсаар болон биеэр зөвлөгөө өгсөн хүн тоо	-

12	БЗЦЦТ –ийн бүтээгдэхүүн олголтын хэсгийн сувилагч, СБЦЦТ, ДГЦЦТ, ажиллаж буй эмч, сувилагч, лаборант нарын танилцуулгыг ил байршуулах	Сэтгэлд нийцсэн үйлчилгээний баг, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба	ДЗБТ, ТТ, НЛТ	+	+	+	+	Тусламж үзүүлж ажиллагсадын мэдээлэл ил тод болно.	Танилцуулгыг байршуулсан байна.	-
13	Мэдээллийн самбарын мэдээллийг тогтмол шинэчилж байх, мэдээллийн зурагтнуудын хэвийн ажиллагааг хангах	Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба	Хамаарах алба, тасаг нэгж	+	+	+	+	Мэдээллийн ил тод байдал хангагдана	Цаг үеийн мэдээллийг тогтмол шинэчилж хэвшсэн байна.	-
<b>ОРИЛТ 4 Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын Дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх чиглэлээр</b>										
14	Коронавируст халдвараас сэргийлэх, бэлэн байдлыг хангах, шаардлагатай хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисын нөөцийн судалгааг шинэчлэн, бүрдүүлэх	Цусны чанар, аюулгүй байдлын алба, Санхүү бүртгэлийн алба	Бүх алба, тасаг	+				Ажиллагсадын аюулгүй байдал хангагдана	Судалгаа хийгдэж, шаардлагатай хамгаалах, хувцас хэрэгсэл халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлсэн байна.	-
15	Ажиллагсадыг томуу, томуу тест өвчнөөс урьдчилан сэргийлж, дархлааг дэмжих	Цусны чанар, аюулгүй байдлын алба, Сувилахуй, үйлчилгээний алба	Бүх алба, тасаг	+	+	+	+	Өвчлөлөөс урьдчилан сэргийлнэ.	Ажиллагсдын дархлааг дэмжих, аминдэмээр хангах үйл ажиллагааг зохион байгуулсан байна.	-
16	Ажиллагсадыг улирлын томуугийн вакцинд тархвар судлалын заалтаар хамруулах саналыг ХӨСҮТ-д хүргүүлэх	Цусны чанар, аюулгүй байдлын алба	Бүх алба, тасаг				+	Ажиллагсдыг томуугийн халдварын эрсдлээс сэргийлнэ.	Томуугийн вакцинд хамрагдах ажиллагсдын судалгааг гаргаж санал ХӨСҮТ-д хүргүүлсэн байна.	-

17	Хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисын зөв зохистой хэрэглээнд дотоод хяналт хийх	Цусны чанар, аюулгүй байдлын алба, Сувилахуй, үйлчилгээний алба, Захиргаа маркетингийн алба	Бүх алба, тасаг	+	+	+	Хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисын зөв хэрэглээ хэвшиж, үргүй зардлыг хэмнэнэ.	Бүх алба, тасаг дотоод хяналт хийгдэж, зөвлөмж хүргүүлсэн байна.
18	Үйлчлүүлэгч болон ажиллагсад учирч болох эрсдлийн үнэлгээг давтан хийх	Эрсдлийн удирдлагын баг	Бүх алба, тасаг	+	+	+	Үйлчлүүлэгч, ажиллагсадын аюулгүй байдал хангагдана.	Алба, тасаг бүрт эрсдлийн үнэлгээг давтан хийж, эрсдлийг тодорхойлсон байна.
19	Хөгжлийн бэрхшээлтэй /сонголын/ иргэдтэй харьцах анхан шатны мэдлэгт суралцах	Сэтгэлд нийцсэн үйлчилгээний баг	ДЗБТ	+	+	+	Тусламж үйлчилгээний хүртээмж сайжирна.	Хөтөч сувилагч нарт дохионы хэлний анхан шатны мэдлэг олгосон байна.
20	Зай хураагуурын хаягдлыг зөв хадгалж, устгуулах	Цусны чанар, аюулгүй байдлын алба, Сувилахуй, үйлчилгээний алба, Захиргаа маркетингийн алба	Бүх алба, тасаг	+	+	+	Байгальд ээлтэй байгууллага болно.	Тусгай зориулалтын түр хадгалах сав ажлын байранд байрлуулан, мэргэжлийн устгалын газарт хүлээлгэн өгч хэвшсэн байна.



ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын  
2020 оны 04 сарын 10-ний өдрийн  
...136 дугаар тушаалын хавсралт



“Эерэг хандлага-Чанартай тусламж, үйлчилгээний эхлэл” аяны хүрээнд алба,  
тасгийг үнэлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: Я.Тогтохням-Хүний нөөцийн ажилтан, хуулийн  
зөвлөх

Нарийн бичгийн дагра: Э.Тунгалагтуяа-Чанар, цусны аюулгүй байдлын албаны  
Чанарын менежер, халдвар судлаач их эмч

Гишүүд:

Ч.Батболд-Стратеги төлөвлөлт, санхүү, бүртгэлийн  
албаны дарга Ч.Батболд

Н.Халиун –Технологийн тасгийн эрхлэгч

Б.Өнөрцэцэг Сувилахуйн албаны дарга